



Төрийн үйлчилгээ

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

III улирал.

Email: D.Urantsetseg@must.edu.mn

Утас: 99291533

Хичээлийн зорилго

- Засгийн газрын үйл ажиллагаа болон шийдвэрийг төрөл, хэлбэр, үүрэг зориулалтаар нь ангилан, хувь хүний болон иргэдийн амьдралд үзүүлж буй нөлөөллийг судлан, дүгнэлт хийх
- Иргэдийн Засгийн газарт санал өгөх боломжуудыг мэдэх
- Нэг цэгийн үйлчилгээ, 1111 төв, цахим машины хэрхэн авах талаар зааварчилгаа, зөвлөгөө мэдээлэлтэй болох

Тулгуур ойлголт

- **Төрийн үйлчилгээ** гэдэг нь өргөн утгаараа Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн зорилт чиг үүргийг бүтээгдэхүүний хэлбэрээр болон үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагын үйл ажиллагаа юм.
- **Нэг цэгийн үйлчилгээ** гэдэг нь төрийн байгууллагуудын төлөөлөгчид нэг дороос үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ
- **Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 1111 төв** нь иргэдээс ирэх санал хүсэлт, шүүмжлэл, гомдол, талархал нэг бүрийг холбогдох байгууллагад шилжүүлэн түүний хяналт, хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгнө.
- **Төрийн үйлчилгээний цахим машин** нь цахим үнэмлэхээр үйлчилгээ хийж, баримт нь улсын бүртгэлийн QR кодоор баталгаажсан нууцлалтай цаасан дээр хэвлэгддэг.

Төрийн үйлчилгээ

- Төрийн үйлчилгээ гэдэг нь өргөн утгаараа Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн зорилт чиг үүргийг бүтээгдэхүүний хэлбэрээр болон үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагын үйл ажиллагаа юм.
- Төрийн үйлчилгээ гэдэг нь явцуу утгаараа засгийн газрын үйл ажиллагаа юм.
- Төр иргэдээс татвар хурааж, буцаагаад иргэдэд олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг.
- Төрийн үйлчилгээ нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, хүний хөгжлийг хангах орчныг бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээжтэй болгох, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад чиглэгддэг юм

Төрийн үйлчилгээний төрөл

- АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ОЛГОДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
- АРХИВЫН ЛАВЛАГАА ҮЙЛЧИЛГЭЭ
- НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ
- НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- УЛСЫН БҮРТГЭЛ /ИРГЭНИЙ БҮРТГЭЛ/
- ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, ТУСЛАЛЦАА
- ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
- ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
- ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА
- УЛСЫН БҮРТГЭЛ /ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ/

Иргэд Засгийн газарт санал өгөх боломжууд

- Иргэд Засгийн газарт саналаа захидлаар илэрхийлэх
- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд саналаа өгөх
- ТҮЦ машинаар саналаа өгөх
- Нэг цонхны үйлчилгээнд хандаж саналаа өгөх
- Засгийн газрын мэдээллын вэб сайтад хандаж саналаа өгөх
- Орон нутагт төр захиргааны байгууллагадаа хандаж саналаа өгөх

Нэг цэгийн үйлчилгээ (НЦҮ)

- Дэлхийн хүн ам хамгийн тархуу суурьшсан улс болох Монгол Улс иргэддээ чанартай нийгмийн үйлчилгээг хүргэх шийдэл нь нэг цэгийн үйлчилгээ юм.
- 2007 онд эхлэл нь тавигдаж, 2013 оноос улс орон даяар нэвтэрсэн нэг цэгийн үйлчилгээ(НЦҮ)-ний төвүүдээр аймаг, сумын түвшинд нийгмийн хамгааллын болон хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө өгөх үйлчилгээ, түүнчлэн нотариатын болон банкны үйлчилгээг үзүүлдэг.
- Нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлтийн болон бусад асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын төлөөлөгчид нэг дороос үйлчилгээ үзүүлдэг.
- Манай улсад Дүнжингарав худалдааны төвд байгаа үйлчилгээ нь энэ төрлийн үйлчилгээний бодит ажил юм.

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР**
1111 ТӨВ

Засгийн Газрын “1111 ТӨВ” нь хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэн, иргэдийн саналыг 10 сувгаар хүлээн авч, түүнд тодорхой хариулт өгч ажиллаж байна. Тус төв нь бүрэн автоматжсан системийг ашигласнаар иргэдээс ирэх санал хүсэлт, шүүмжлэл, гомдол, талархал нэг бүрийг алдахгүй хүлээн авч холбогдох байгууллагад шилжүүлэн түүний хяналт, хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгнө.

Тус төв дээр байрлах санал бичих машин (Киоск) ашиглан өөрийн санал хүсэлтээ хурдан шуурхай оруулах боломжтой.

Төрийн үйлчилгээний цахим машин (ТҮЦ)



"ТҮЦ" машинаар дамжуулан иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах бөгөөд яам, агентлаг, төрийн байгууллагуудад өөрийн санал хүсэлт, өргөдөл гомдлоо илгээх боломжтой юм. Үүний үр дүнд иргэний цахим үнэмлэх анх удаа олон нийтийн хэрэглээнд нэвтэрч байна.

“ТҮЦ” машины үйлчилгээний баримт нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт ашиглагддаг QR кодоор баталгаажсан нууцлалтай цаасан дээр хэвлэгдэх бөгөөд ямар нэгэн байдлаар дуурайлгах, хуулбарлах боломжгүй юм.

Даалгавар-1

Дараах асуултанд хариулж бичээрэй.

1. Болдын гэр бүлд үзүүлж буй төрийн үйлчилгээг төрлөөр нь ангилж, зураглал хийх
2. Болдын хүүхдүүдэд хэрэгтэй байгаа төрийн үйлчилгээг хүргэх асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ?

Нийслэлийн СБД-ийн 13-р хорооны иргэн Болд, Цэцэг нар ам бүл дөрвүүлээ амьдардаг. Аав Болд төсвийн байгууллагад ахлах мэргэжилтнээр, ээж Цэцэг хувийн байгууллагад нягтлан бодогчоор ажилладаг. Болдынх саяхан хашааны газраа зарж хотын төвд 3 өрөө орон сууц худалдан авсантай зэрэгцэн эхнэр Цэцэг нь амаржиж хүүтэй болсон. Том охин Халиун ЕБС-ийн 10 дугаар ангид сурдаг бөгөөд түүнд шилжин суралцах шаардлага үүсэн ч одоогоор хуучин сургуульдаа явж байгаа. Шинээр мэндэлсэн хүүдээ Хангал гэж нэр өгсөн бөгөөд энэ гэр бүл аз жаргал, инээд хөөрөөр бялхаж байна.

Даалгавар-2

Дараах асуултанд хариулж бичээрэй.

Эх сурвалж: Засгийн Газрын “1111 ТӨВ”-д ирсэн иргэдийн санал

1. 100 айлын Иргэний бүртгэлийн 2 дугаар байрыг завсарлаж байгаа гээд тойруулаад маш том хашаа барьчихсан. Зорчих хэсэг нь саадтай болчхоор тэргэнцэртэй иргэд орж гарах нь хүндрэлтэй байна. Яаралтай шийдвэрлэж өгнө үү.
2. Маскны худалдаанд хяналт тавина уу. Коронавирусын халдвартай холбоотойгоор маскны үнэ 150 төгрөгөөс 1500 төгрөг хүрлээ. Фэйсбүүкээр дүүрэн авна, зарна гэсэн хүмүүс, ченжүүд ч их байх шиг. Хяналтгүй ихээр зарагдахын үр дагавар нь 1. Хэт үнэтэй болж хүмүүс авч чадахгүйгээс бол маск зүүж чадахгүй, халдвар тархах эрсдэл нэмэгдэнэ. 2. Маскны ченжүүд .

Гэрийн даалгавар

1. Даалгавар 1,2,ыг дэвтэртээ хийгээрэй.
2. ТҮЦ машины <https://tutsmashin.gov.mn/> сайт руу орж, төрийн ямар ямар үйлчилгээ авч болох талаар мэдээлэл бэлтгэж ирнэ үү.
3. Сурах бичгийн 114-117 хуудсыг сайн уншиж судлаарай.